



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Хорооны 2016 оны 94 дүгээр тогтоолд
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2, 63.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хорооны 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 94 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг дараах байдлаар өөрчлөн тогтоосугай.

№	Эрхлэх үйл ажиллагаа	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ (Сая.төгрөг)
1.	Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	10.0
2.	Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа	50.0
3.	Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа	50.0
4.	Андеррайтерийн үйл ажиллагаа	200.0
5.	Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа	2,000.0
6.	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа	2,000.0
7.	Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа	1,000.0
8.	Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа	1,000.0
9.	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа /кастодиан/	1,000.0

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭГЭГЧ,
ДЭД ДАРГА  Б.БАТБОЛД

